

ИНЖАННАШИЙН “НЭГЭН ДАВХАР АСАР”, “УЛААНАА УХИЛАХ ТАНХИМ”
ХОЙМСОН РОМАН ДАХЬ МОНГОЛЫН АМАН ЗОХИОЛЫН
УЛАМЖЛАЛЫГ ТОДРУУЛАХ НЬ

Х.Нандин-Эрдэнэ

Abstract: “One-Storey Pavilion” and “The Chamber of Red Tears” novels by Injannash were enriched the narrative and lyrical traditions of Mongolian literature supported on traditional methods of Chinese literature. It was revealed artistic feature of Mongolian literature using Mongolian folklore such as riddles, proverbs, sky worship, chronology and symbols of the number nine.

Finally, “One-Storey Pavilion” and “The Chamber of Red Tears” by the great writer Injannash were enriched Mongolian epic traditions which inhering Mongolian and Chinese folklore and written literary traditions. This article intends to analyze and to summarize on examples of expression of traditional customs and symbolic thinking of Mongolian literature. The article consists of such parts: riddles, proverbs, symbols of the number nine and traditional customs including comparative examples of Mongolian and Chinese.

Түлхүүр үг: *Онъсого, зүйр үг, хуурын үлгэр, бэлгэдэл, зан заншил, хуримын ёс, хадаг барих ёс, тамхилах ёс*

Удиртгал

Эмэгтэйчүүдийн эмгэнэлт хувь заяагаар дамжуулан эрх чөлөөг эрхэмлэх үзэл санааг агуулсан нэгэн бүтээл бол монгол туургатны их зохиолч Инжаннашийн туурвисан “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон роман юм. “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон роман нь уянгын өнгө аястай, хайр сэтгэлийн түүх, охид бүсгүйчүүдийн эмгэнэлт хувь тавилангийн хүрээнд бүтээгдсэн, дорно дахины ард түмний оюун санаа, уран сэтгэмжийн өвөрмөц онцлогийг дэлгэн харуулсан зохиол юм.

Уг хоймсон романд Хятадын уран зохиолын сор болсон бүтээлүүд их бага хэмжээгээр тусгалаа олсон болохыг олон эрдэмтний судалгаа батлан харуулдаг. Тухайлбал: Хятадын уран зохиолын сонгодог бүтээлийн нэг болох Цао Шюэчиний “Улаан асрын зүүд” романы үзэл санаа, туурвил зүй, уран сайхны арга хэлбэрийг гол болгон ашигласан болохыг эрдэмтэн Залгаа “Улаан асрын зүүд, Нэгэн давхар асар болон Улаанаа ухилах танхим” бүтээлдээ олон талаар тайлбарлан дүгнэжээ. Түүнээс гадна Ли Ружэний “Толь цэцгийн барилдлага”, “Улаан асрын зүүдний үргэлжлэл”, “Дараагийн Улаан асрын зүүд”, Чень Дуаньшэн “Дахин төрөх барилдлага” зэрэг бүтээлүүдийн уран сайхны арга хэлбэрийг дам хэлбэрээр ашигласан болохыг хятадын эрдэмтэд судлан тогтоогоод байна. Их зохиолч Инжаннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романы судалгаанд хятадын бичгийн уран зохиолын харилцааг тодруулах судалгаа багагүй хувийг эзлэх ч Монголын уран зохиолын уламжлалыг тодруулах судалгаа ховор хэвээр байна. Бид уг судалгаанд “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд дүрслэгдэх Монголын уламжлалт ахуй, зан заншлын холбогдолтой элементүүдийг түүвэрлэн авч задлан шинжилсэн болно.

Онъсого, зүйр цэцэн үгийг тусгасан байдал: “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд монгол ардын аман зохиолын төрөл зүйлийг уламжлан авч шинэчлэн ашигласан жишээ олон байдаг. Ингэхдээ утгыг далдлан өгүүлэх, адилтгал, зүйрлэл, үлгэрлэл мэтийн утгын чимэг, урнаар өгүүлэх гэх мэт дорнын утга зохиолын аргаас чадмаг ашиглаж онъсого тааврын маягтай өгүүлдэг. Энэхүү өгүүлэмж нь “Улаан асрын зүүд”-ний

“Лю Шюэ Тинд үзэмжийн шүлгийг нийлүүлэн холбож
Нуань Шян жилийн онъсогыг урлан зохиов”

(Цао Шюэчинь. 2017: 648-649)

гэх 50-р бүлгийн утга агуулгатай тохирдог. Зохиолд Күнзийн сургаал, Эртний хүний нэр болон Сүн У Күн нарыг далдалсан утга бүхий тааврыг хэлэлцэж байгаагаар гардаг. Жишээлбэл: “Арьяабал бурхан алдарт үүлнээ уламжилсангүй” гэх таавар (Хариу нь: Хэдий сайн боловч баримт үгүй болой гэсэн “Дөрвөн бичиг” дэх сургаал), “Урсах усан чулууны хажуугаар жихүүн амьсгал гаргана” гэх таавар (Хариу нь: Уулын үер гэх утгатай “Шань Тай” эрхмийн нэр) зэрэг эртний ном судар, мэргэдийн нэрийг таалцахаас гадна:

Урсгал цүнхээл ангижран салж
Улаан тоос эвхрэн наадъя уу
Учир сонирхол юун бэ
Ашиг нэр ашид хоосон
Алсын хэргийг залгахуйяа бэрх

(Хариу нь: бич самж)

гэсэн өгүүлэмжид дорно дахины онъсого тааврын онцлогийг харуулаад зогсохгүй хятадын уран зохиолын алдартай бүтээлүүдээс ашигласан байв.

“Нэгэн давхар асар”-ын 5-р бүлэг:

“Цэцэгт зул дор хуримларуун хүн саран хамтаар дүгрэг
Битүү толийг тайлруун, үг бэлгэ бүрнээ уянгатай”

гэсэн оршил шүлгээр эхэлж Бэй хороон дахь эмэгтэйчүүд болон Пү Юй нар 30 гаруй онъсого таавар таалцаж байгаа тухай өгүүлэмж гардаг. Тэдгээрт монгол ардын онъсогыг шууд хэрэглэснээс гадна шинээр онъсого хэлбэрээр оруулсан таавар багтаж байв. Жишээлбэл:

- (1) Эрдэнэ оюугийн өнгөтэй
Эрс тэс явдалтай
Эрхий чинээхэн биетэй
Эр хонгор дуутай
(ногоон голио)
- (2) Хөлгүй хэвтээ явагчийн дэргэд
Хөлсгүй ороонго ноён сууж
Сүүж үгүй түшмэлээ зараад
Сүүлгүй баатрыг барь хэмээмүй
(ус, могой, загас, мэлхий)
- (3) Бүжигч хулгай санг зөөхийн учир
Бүгэгч дарга шөнө сахиж сууруун
Бүгшин явагч хиа лугаа зохилдоод
Бүгдийг сэрээгч бөөгийн дуу гаргамуй
(хулгана, муур, тахиа, нохой)
- (4) Баатар бус идтэй
Баян бус эдтэй

Барс бус эрээн
Багш бус номтой

(зөгий)

Монгол ардын оньсогод аливаа мал амьтныг “баатар” гэж зүйрлэн адилтгадаг онцлогтой тухай эрдэмтэн Г. Ловор тэмдэглэсэнчлэн “Нэгэн давхар асар” романд тэдгээр уламжлалыг харуулсан оньсогыг нэг бус удаа ашиглажээ. Түүнээс гадна нүүдэлчин ардын ахуй соёлын илтгэх үг бүхий оньсого багтсан байна. Жишээлбэл:

- (5) Алтай хангайн ар дор
Алим чавга төрвэй
Ах дүү арвуул авч эс чадсаныг
Алагдай Цалагдай хоёул амандаа үмхвэй

(хоовон, гал, таван хуруу, хавчиг, хусуур)

- (6) Хар хурган малгайтай
Хавтгай бөгтөр биетэй
Шор шор явдалтай
Шолдон хөх морь

(хуруувч, зулаг, утас, зүү)

Энэ мэт монгол ардын оньсогоос гадна зохиогчийн өөрийн зохиосон оньсого хэлбэрийн таавар бий. Жишээлбэл:

- (7) Хүчин буурч нуруу бөгтийгөөд цэр цустай
Хөдлөн ядан бүгшин хэвтээд дуун уянгатай
Хүзүүгээ гүлдийн нүдээ аньж дуун амьсгахгүй
Хөгшид баярлан, эхнэр айж, нялхас уйлмуй

(өтлөх, өвдөх, үхэх, төрөх)

- (8) Хиргүй ариун толио хөмрөөд
Хив торгоо давхар давхар дэвсбэй
Хилэв хилэв хэт хэт цахиурыг цохин
Хэнгир хангир хатгуур бугуйвчаа таягдвай
Оюу шүрийн оосроо татаад
Уйлан хайлан нулимсаа асгаруулвай

(огторгуй, үүл, цахилгаан, аянга, солонго, бороо)

Дээрх жишээнээс харвал “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд монгол ардын аман зохиолын нэгэн төрөл болох оньсогыг авч хэрэглэсэн нь “Улаан асрын зүүд” зохиолоос ялгарах уран сайхны онцлогийн нэг болж байна.

Онсьогоос гадна монгол ардын зүйр цэцэн үгийг өргөн ашигласан байв. Жишээ нь: “Жороо морь намар, хээнцэр хүн хавар”, “эрхийг сургахаар бэрхийг сурга”, “ам алдвал барих дор бэрх, агт алдвал барих дор амар”, “тэмээний том хэдий элэвч, илжигний тохон гарахгүй буй”, “дээл хувцасны шинэ ану сайн, ураг садны хуучин ану сайн” зэрэг монгол ардын зүйр үгийг дүр тодотгох, адилтгах, зэрэгцүүлэх үүргээр ашиглажээ. Жишээлбэл Лао Тай Тай, Жинь Фү Рэнь хоёр Пү Юйг хэнтэй ураглуулах тухай хэлэлцэх үедээ эмгэн “Миний санаа болбоос мөн баян эрхмийг эрэх хэрэггүй, даанч санаан дор үлээгдэн унаагдах мэт сайхан хүн мөн хэрэггүй. Гагц үүд өрх тэнцэх бөгөөд насан тэнцүү, ухаан томоо ану сайн болоод бахь зузаалаг ану сайн. Эртний үгэн дүр дээл хувцасны шинэ ану сайн, ураг садны хуучин ану сайн хэмээжихүй ” (Injannasi. 1979: 369-370) гэж зүйр үгийг үндэс болгон эртний найртай Чин Мө бүсгүйг бэрээ болгохоор сонгодог. Зохиолд орсон нэгэн сонирхолтой үг бол “тэмээний том хэдий элэвч, илжигний тохон гарахгүй буй” гэсэн зүйр үг юм. “Улаан асрын зүүд”-ний 6-р бүлэгт “瘦死的骆驼比马大, 你老拔根寒毛, 比我们的腰还粗呢 ” (Цао Шюэчинь. 2014: 104-

105) буюу “Турж үхсэн тэмээ, адуунаас том: Юу ч болсон та нэг ширхэг үсээ сугалавч мань нургуунаас идэрүүн болой” гэж ядуу эмгэний эрээ цээргүй үгийг их зохиолч өөрийн бүтээлдээ “тэмээний том хэдий элэвч, илжигний тохон гарахгүй буй” гэсэн ганц үгээр илэрхийлжээ. Хишиг горьдож ирсэн ядуу эмгэн “Бэй хорооныхны хур хөрөнгийг хэд хуваалаа ч дундаршгүй болохыг” ийнхүү зүйр үгийг ашиглан шулуун хэлж орхисон нь түүний эрээ цээргүй занг илтгээд зогсохгүй хошин өнгө аясыг илэрхийлж байна.

“Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” романд хуурын үлгэрийн тухай цухас дурддаг нь үнэтэй сурвалж юм. Тус зохиолын 17-р бүлэгт: “Тэр үед 4 сарын шинэд тул цонх гэгээвчээ цөм нээж, Гү Ши ноён Ши найнай лугаа сул суудалд нэгэн сохор хуурчийг суулгаж үлгэр хэлүүлэв. Тэр сохор хуурч хөвч чавхдаж “Ши Тан бичиг” -ийг хэлснээр олон хувилгаан бүгдээр хүч нийлж Жин Бэйфөнийг дарж чадсангүй. Сүн Бин цухалдаж Хуа Гуошань уул дахь Сүн Үкүнийг заларч ирүүлэх хөгжилтэй газарт хүрч байтал гэнэт даян цохих чимээ сонсож хэрэг байхыг мэдээд яаран тэвхээ унагаж үлгэрийг цэглэв” (Injannasi. 2018: 299-300) гэж өгүүлдэг. Энэ хэсэгт хэдийгээр хуурын үлгэр гэсэн үг өгүүлбэр байхгүй ч “сохор хуурч”, “хөвч чавхдах”, “үлгэр хэлүүлэв”, “тэвхээ унагаж”, “үлгэрийг цэглэв” гэсэн үгнүүд нь хуур татаж үлгэр өгүүлж буйг илтгэж байна.

С.Байгалсайхан (2015) ХХ зууны дунд үеэс монголын зарим хуурчид хятадын түүхэн романаас сэдэвлэн өгүүлэхээс гадна монгол бичгийн болоод аман зохиолын бэнсэн үлгэрийн маягаар аялгуулан хайлах болжээ. Энэ тухай эрдэмтэн Цогт “Хуурын үлгэрийн судлал” номдоо дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Өвөр монголын залуу эрдэмтэн Хувьсгалт (2009) “Бэнсэн үлгэр бол хятад үлгэрийг амаар хэлдэг учир хятад монголын уран зохиолын харьцааны судлалд холбогдох нь дамжиггүй. Бэнсэний үлгэр нь олон талаар хятад монгол уран зохиолын харьцааг судлахад чухал ач холбогдолтой” гэж тайлбарласан байдаг. Дээрх эрдэмтдийн үзэж байгаачлан Хуурын үлгэр нь монгол хятадын уран зохиолын харилцан нөлөөлөл тэдгээрийн уламжлалыг тээгч үнэт дурсгал аж. Инжаннашийн “Улаанаа ухилах танхим” зохиолд энэхүү хуурын үлгэр дүрслэгдсэн талаар Өвөр монголын эрдэмтэн Б.Цогт “Монгол үндэстний бичгийн их хүмүүн Инжаннаши болон хуурын үлгэр “Их баруун Лян” өгүүлэлдээ дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Түүний үзэж байгаагаар уг зохиолд гардаг “Баруун Тангийн бичиг” хэмээх үлгэр нь хятадад дэлгэрч байсан “Их баруун Лян” гэдэг зохиол болохыг олон баримт дурдан дүгнээд, Инжаннаши нь хуурын үлгэрээр дамжуулж монгол үндэстнийхээ эх түүхийг таниулан уламжлуулах зорилго агуулж байсан болох таамаг дэвшүүлжээ (Цогт. 2017: 172-173).

Есийн тооны бэлгэдлийн илрэл. С.Байгалсайхан (2015) юмс үзэгдэлд олон дахин давтагддаг түгээмэл, эсвэл тухайн улс үндэстний хайрлан хүндэтгэдэг, жигшин дургуйцдаг зан заншил, ахуйн сэтгэлгээний тогтсон ойлголт нь бэлгэдэлт сэтгэлгээний шинж тэмдэг юм. Дэлхий улс орнын Үндэстэн угсаатан бүр сүсэг бишрэл, уламжлалт сэтгэлгээнээс улбаатай өөр өөрийн тооны бэлгэдэлтэй байдаг. Монголчуудын хувьд есийн тоог бэлгэдэн дээдэлдэг ёс уламжлал бий.

“Нэгэн давхар асар”-ын 23-р бүлэгт “Үнээрэн эртний үе дүр онц энэ есийн тоог хэрэглэх ину юун аж. Бурхны сургуулийн шавь нарын барих долдой дор бас есөн гархи холбожихуй. Пү Юй өгүүлрүүн: За, Есөн холболзог гархийн есөн гархи даруй долдойн есөн гархи өлгөсөн санаа мөн. Юань улсын Тай-Зү хаан Онон мөрний хөвөөн дүр хааны суурин дор суухдаа өрлөг таван хариа цуглуулж есөн манжлагат тугаа босгов. хэмээсэн ину мөнхүү тэр санаа. Шинь Рү инээн асууруун: Дэмий л тэр санаа хэмээх ину эгнэгт аль санаа вэ? Пү Юй инээн өгүүлрүүн: Даруй есөн холболзог гархийн санаа мөн. хэмээсэн дүр олон хүн их л инээлцэв. Чинь Зы-ше өгүүлрүүн: Есийн тоог эрхлэх ину гагц эртний үе дүр бус. Энэ үе дүр хойд газрын вангууд нийслэл хот дор хүргэх ину бас есөн цагааны алба хэмээж байхгүй юу.” Дэ Чин өгүүлрүүн “Есийн тоог хэлбээс харин маш олон. Тэнгэр дүр болбоос есөн одон. Газар дор болбоос есөн гол мэнгэ. Балгасан дор болбоос есөн жөү хэмээх зүйлийн тоо буй. Эгнэгт юуны учир есийн тоог ийн эрхэлснийг мэдэхгүй” гэжээ. Энд есөн гархи гэдэг уламжлалт тоглоомоос үүдэн есийн

тооны тухай мэтгэлцэж байгааг дүрсэлжээ. Үүнд: есөн цагааны алба, есөн одон, есөн мэнгэ, есөн жөү (тойрог), есөн манжлагат тугийг дурдсан нь Монгол, Хятад мөн дорнын зурхайд багтах есийн тооны бэлгэдлийг илэрхийлсэн байна. Түүнчлэн есөн цагааны бэлгэдлийн уламжлал жирийн иргэдэд хэрхэн уламжилж ирснийг тус номын 29-р бүлэгт тодорхой өгүүлдэг. “Хэрэв Жүнь Шинь фүгээс бэлэг хүргэхийг хэлээрээ ирвээс илүү явдал болох хэрэггүй. Өвлийн сүүл сар даруй хүүхний тал сар тул бэлгийн юмыг боловч буулган аваараа ирэх лүгээ хамт ацар тушаа хэмээхтүн. Манай гэрийн хүүхэн өгөх ёсны бэлэг угаас хүнд тул, ургийн газар мэдээ өгч эртхэн бэлтгэхүй дүр сайн. Бэй Хөү нээж үзвээс мөнгөн буйлт цагаан тэмээ тэргүүтэн нэг ес, эмээл хазаарт морь тэргүүтэн хоёр ес, хонь тэргүүлэн шүүс гурван ес, арз тэргүүтэн архи гурван ес чухам биеийг авах буй за. Үнэ мөнгийг хэрэглэхгүй хэмээжихүй” гэж “есөн цагаан алба”-с үүдэлтэй хуримын сүйн бэлгийг дүрсэлжээ. Есөн цагааны албын тухай Ц.Насанбалжир (1964) “Ар Монголоос Манж чин улсад залгуулж байсан алба” номд “Есөн цагааны алба гэдэг нь 1635 онд Сэцэн хан анх Манжийн Эээр засагч хаанд найман цагаан морь, нэг цагаан тэмээгээр бэлэг барьснаас эхлэн 1691 он хүртэл есөн цагааны бэлэг нэртэйгээр үргэлжилсэн байна. Харин 1691 онд Манж нарыг халхыг эрхэндээ оруулж авсныхаа дараа есөн цагааны хуулиар алба болгон хувиргажээ” гэж тайлбарласан байдаг.

Есөн жөү гэдэг нь эртний хятадын нутаг дэвсгэрийн хуваарь бөгөөд Янь ди, Хуан дигийн үед хятадын газар нутгийг есөн жөүд хувааж байсан шалтгаан нь эртний хүмүүс тэнгэрийг бөөрөнхий, газрыг дөрвөлжин гэж үздэг байсан бөгөөд дөрвөлжин газрыг есийн тооны битүү гэсэн утгаар бэлгэдэн нэрлэдэг байсантай холбоотой. Тиймээс эртнээс нааш хятадын нутаг дэвсгэрт оршин тогтнож байсан төрт улсууд газар нутгаа есөн тойрог мужид хувааж ирсэн түүхтэй. Гэвч тогтоосон хуваарь нь тухай бүр өөр өөр байсан ажээ.

Жишээнд өгүүлэх есөн манжлагат туг нь есийн тооны бас нэгэн бэлгэдэл бөгөөд монголчуудын хувьд гурвын тооны дээд бэлгэдэл болох тухай “Монгол ёс заншлын үндэс дээжис” номд дурджээ. “Нэгэн давхар асар”-т өгүүлэх есөн манжлагат тугийн тухай нэрт орчуулагч Ц.Сүрэнжав “Есөн хөлт цагаан туг”-ийг зарим нь есөн иштэй гэх, есөн хэсэг морины сүүл буюу сарлагийн сүүлээр салхинд хийсэх манжлага хийсэн гэх, зарим нь бөс тугийн хормойд есөн бүч буюу манжлагыг эгнүүлэн хадсан гэх, бас зарим нь “есөн хөлт” гэдэг нь “есөн хөхөлт” гэснийг ташаарсан байж болно гэдэг ажээ. 1640 онд “Юань улсын түүх”-ийн хаадын намтрыг Дүдинг, Өлзийт нар манжаас монголд орчуулахдаа “есөн манжлагат цагаан туг” гэж анх буулгажээ. Хожим үзэмчин гүн Гомбожав 1725 онд “Гангын урсгал” зохионгуйг “Юань улсын түүх”-ийг ашиглан туурвихдаа “есөн манжлагат” гэснийг нь засамжлан “есөн хөхөлт цагаан туг” болгон өөрчилсөн нь судар бичигт ийм хэллэг анх орж ирсэн хэрэг болжээ. 1739 онд Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хэгээст бичиг”-т “есөн хөлт цагаан туг” гэж тэмдэглээд зарим бичигт бас “есөн хөхөлт хэмээму” гэсэн зүүлт хийжээ. “Есөн хөлт цагаан туг” нь нэг гол сүлд ба найман элч сүлднээс бүрддэг байна.

“Нэгэн давхар асар”-т есөн тооны бэлгэдлийг илэрхийлэх дээрх жишээнээс гадна 30-р бүлэгт худын газар очоод бэрийн эрдмийг дагаж явахыг сануулсан хэсэг бий. “Хүүхэн чи харьд очих тул миний үгийг сайхан тэмдэглэ. Бэр болоход есөн зүйлийн хууль бий. Нэгийг осолдвоос болохгүй.

- Оёх тавихыг хичээх
- Идэж уухыг хэмжээлэх
- Бодох ухахыг хянах
- Зүрхийг бага үгийг зөөлөн болгох
- Биеийг сахин бат зоригтой болох
- Дуулах гиншихийг цээрлэ
- Үг дууг үл хөөх

- Хадам харийг хүндлэх
- Алжаа залхууг тэвчих”

гэж өгүүлдэг бол Монгол ардын аман зохиолд:

- Үйлэнд уран
- Үгэнд цэцэн
- Үрдээ энэрэлтэй
- Үргэлж цэмцгэр
- Ханьдаа түшигтэй
- Хадамдаа элэгтэй
- Найранд дуутай
- Настанд өргөлтэй
- Нартад буянтай байхыг сургадаг (Арьяасүрэн нар, 1992: 401-402)

гэсэн сургаал байдаг.

Уламжлалт зан заншлын илрэл. Монгол хуримын ёсонд сүй тавих ёслолыг гүйцэтгэхээс өмнө хүргэн бэрийг билигт сайн өдөр гэрээс мордуулдаг байсан уламжлал түгээмэл. “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романаас тэрхүү хэв ёстой холбоотой олон жишээг харж болно. “Жич өдөр луу цаг дор мордох тул Жи сан-е Пү Юйг дагуулж, Лао тай тай дор архи өргөн бэлэглэж сайн ерөөл гуйн салах ёсоор мөргөж гарахуй дор Мяо Луань, Шю Фэн тэн Пү Юйгийн зүг баяр хийж өгүүлрүүн”. Үүнтэй адил сүйт залуусыг луу цагт мордуулдаг ёсыг нэг бус удаа дүрсэлсэн байгаа нь “Хүргэн ихэвчлэн луу цагт ирэх нь олонтоо тохиолддог. Хэрэв луу цагаас эрт ирсэн байвал хээр бууж цагаа хүлээнэ” (Ред. Сампилдэндэв. 1997: 165-166) гэдэг цахарын хуримлах ёстой ижил байна. Түүнээс гадна хуримын найранд зочдыг хөлчүүрэн согттол нь дайлж цайлдаг уламжлалтай. “Нэгэн давхар асар”-ын 30-р бүлэгт шинэ бэрийн өрөөнд хуримд оролцсон халамцуу авгай нар ирэн ярих төвөг удаж байгааг дүрсэлдэг. Жишээ нь: “Хурим дүүрсэн өдөр Бай лао-гуа бас ууж согтоод таяг тулсаар тэмтэрхийлэн мантархийлэн бүжиглэн сарвалзан шинэ гэр түр орсон тул Сү Жи угаас тиймийг үзүүдүй тул их л айв. Дагал тур Жан ма-ма, Ван лао-лао хоёул бас хагас гэлмийж чирэлдэн өргөлдсөөр орж ирсэн дүр Сү Жи сая согтсон эмгэдийг мэдэж найр тавин цай уулгахуй дор гурвуул даруй их дуугаар бархиралдан хэлэлцэн “Лао тай-тайгийнхаа хүнд хишиг дүр согттол уув. Бид хас агь юун ийм сайхан хосгүй баяр дор уухгүй бид хэзээ уумой” хэмээн алгаа ташиж эгээ төгөөгүй аашлахуй дор” зэргээр дүрсэлдэг.

“Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд нүүдэлчин ахуйн онцлогийг илэрхийлэх идээ ундаа, өмсгөл зүүлт, уналга, байр сууц, эрхлэх аж ахуйн төрөл зэргийг дүрслэн зурагладаг. Тухайлбал: Морьтой холбоотой 250 гаруй өгүүлэмж байдаг бөгөөд эдгээрийн 80 хувь нь морийг уналгад ашиглаж байгаагаар гардаг. Жишээлбэл: “Пү Юй сая аяарлан гарч их хаалганы өмнө хүртэл үдэж гарсан Чин Кө шянь-шэнгүүд ба өвгөн гуан-жя нарыг найр тавин эргүүлж аймшиггүй тэргэн дүр суухгүй, Ван Юань Кай, Гао Жянь Фү хоёр хүн сийлмэл эмээл, цацагт жолоотой нэгэн тарган цагаан морийг хөтөлж ацарсан хойно Фү Хай яаран эмээлийн дэвсгэрийг ачиж, Гао Тин ташуурыг өргөн, Ма Жү дөрөө дарснаар Пү Юй алгуураар морин дор унасан хойно, Фү Хай өмнө зам удирдан олон дагагсад нэгэн зэргээр алавхийлэн мордож, Ван Юань Кай, Гао Жянь Фү хоёул өмнө нь морь хослон явж Гао Тин, Ма Жү хоёул Пү Юйгийн хоёр хажуу дор ойрхон хамгаалж Яо Жинь, Бао Жянь, Чи Шү, Гү Хуа дөрвөн хөвгүүн морины хойдтой шадар дагаж Юн Жү, Бө Лин тин сүүл дүр болж нэгэн сүрэг хүн өмнөш зорив.” Энэ хэсэгт Пү Юй болон түүний дагалдагч нар бүгд морь унаж байгаагаас гадна “ташуур”, “эмээл”, “дөрөө”, “жолоо” гэх мэт адууны эдлэл хэрэгслийг дүрсэлсэн нь тухайн үеийн залуусын уналгын нийтлэг төрөл нь адуу байсныг харуулахын зэрэгцээ морьтон монголын онцлогийг ч тусгажээ. Энэ тухай “БНМАУ-ын угсаатны зүй” номд “Малыг уналга,

тээвэрт зонхилон үүрэг гүйцэтгэхээр адууг унааных, тэмээг унаа, тээврийнх, үхрийн тэрэгнийх гэж ангилж болно.” гэж тайлбарласан байдаг.

Уналгаас гадна адуу нь орлогын эх үүсвэр болдог тухай дүрслэл бий. Жишээлбэл: “Жян Наньд буун адуугаа зарах далимдаа охиноо эргэхээр болов.” гэдэг өгүүлэмжээс үзвэл тухайн цагт өвөр говьд хонь малаа адгуулахаас гадна худалдан борлуулдаг үзэгдэл түгээмэл байсныг харуулж байна. Үүнийг батлах өөр нэг жишээ бол “Тай тай бас “Үхэр мал хэдий буй?” хэмээн асуусан дор эмгэн даруй зовлонгоо тоочин үүсгэж огт зогсохгүй бөгөөд бас зүхэж өгүүллрүүн: Амиа алдсан Да Ин Зы айлын Пэн Шазы манай амуу индэх нэгхэн илжигийг гурил цайлгамой хэмээн заалж аваачаад, юуны гурил цайлгах аж харин гүү мориноосоо луус авмуй хэмээн оролдож арван хэд хоносон дор би Эр Ма-зыгаар авуулаар илгээвээс илжиг нэгэнтээ турж явж чадахгүй болжихуй.” гэсэн өгүүлэмжээс нүүдэлчин болон тариаланч ахуйн хосолмол хэлбэр харагдаж байна. Энд дурдагдсан “айл” гэдэг үг нь тухайн үеийн засаг захиргааны нэгж бөгөөд энэ тухай “Хятадын угсаатны зүй” номд дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. “Нэгэн давхар асар”-ын 17-р бүлэгт “Түргэнээ жасааны хуягууд, айлын дарга нарыг дууд хэмээгээд бие эргэн их гэртээ орж нэгэн хөвөө ину барсан жинст малгай өмсж гартаа эрх барьж гарч ирэв.” гэсэн хэсэгт “жасаа”, “айл” гэсэн засаг захиргааны нэгжийг дурджээ.

Түүнчлэн монголчуудын идээ ундаа, хоолны хэрэгсэлтэй холбоотой соёлын хэлбэр тусгалаа олсон олон жишээг харж болно. “Пү Юйгийн зам дор идэх өрөм, хурууд, хуурай идшийн зүйлийг нэлээд өгсөн хойно Пү Юй сая Рэнь Хань Шү Ү дүр ирж Лао еэ дор учрав.”: 16-р бүлэгт: “Лао тайтай Мэн мө мөг дуудаж Фү Шөүг тушааж, Пү Юйгийн их үст хувцас хунар ба гадари аваачих аяга савх аливаа хэрэглэлийн зүйлийг эртхэн бэлтгэж гадна дагаж эчих хүүхэд дүр тушаалгав.” гэх зэрэг өгүүлэмжид цагаан идээ дүрслэгдсэнээс гадна монгол хүн бүр өөр өөрийн аягатай байсан бөгөөд аян замд явахдаа ч аяга сэлтээ авч явдаг байсан ёс уламжлал дүрслэгджээ. Тэгээд ч монгол ардын зүйр үгэнд “аягагүй бол амгүй” гэсэн хэллэг бий.

“Нэгэн давхар асар”-т гарах өвөрмөц нэгэн зан үйл бол “хүүхэд шургуулах” уламжлал байв. “Нэгэн давхар асар”-ын 3-р бүлэгт “Аа, үнээрэн манай агийг сая төрмөгц чам дор шургуулав хэмээмү.” гэж Пү Юйг төрмөгц Бай лао-гуад шургуулж байсан тухай; 17-р бүлэгт “Мэн Шэн болбоос лао-еэгийн шургуулсан хөвгүүн” гэсэн харилцан яриа гардаг нь монгол үндэстний хүүхдийн насан хутгийг уртасгахын тулд өнөр өтгөн гэр бүлтэй айлын эхнэрийн хормойд шургуулж гаргадаг домоос үүдэлтэй сонирхолтой зан үйл юм.

Тамхийг анх Өмнөд Америкт хэрэглэж эхэлсэн бөгөөд XVI зууны үед испани, португалчууд Европ тивд авчирснаар дэлхий даяар тархсан түүхтэй. Хятадын Мин улсын үед Филиппинээс авчирсан тамхины ургамлыг Тайвань, Фү жяньд нутагшуулж байсан мэдээ бий. Улмаар хятадаар дамжин Монгол, Төвөдөд нэвтэрсэн байна. Тамхины хэрэглээ нь ийнхүү нэг тивээс нөгөө тивд дамжин тархах явцдаа тухайн бүс нутгийн ард түмний өвөрмөц соёлыг өөртөө хэвшүүлж байсан юм. Тухайлбал тамхины хэрэглэлийн нэр төрөл олширч (гаанс, хөөрөг, даалин, гаансны уут г.м), түүнтэй холбоотой хэв дадлын зан үйл ч бий болсон байна. Дорно дахины ард түмэн тэр дундаа Монгол, Хятад, Төвөд зэрэг орнуудад хамрын тамхи, амны тамхи өргөн тархаад зогсохгүй хэв дадлын өвөрмөц хэлбэр болтлоо нутагшжээ.

Тамхитай холбоотой дээрх ёс заншил монголчуудын хувьд ч мөн гар урлал, оюун санааны үнэт өв болон уламжлагдан ирсэн түүхтэй. Тухайлбал монгол эрийн гоёлд зайлшгүй багтах эд хэрэгсэл бол хөөрөг, гаанс юм.

Инжаннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд тамхитай холбоотой дараах өгүүлэмжүүд бий.

Бурхан! Би эндэхийн ёсыг үл мэдэх бус. Яамаар оръя хэмээвээс Хөү-ийн үүд далай мэт гүн бөгөөд би энэ үеийн шинэ гуняан, най най нарыг танихгүй тул Да нян чамайгаа эрж ирэв. Баахан харгалзах болмуй. Хэмээн нэгэнтэйгүүр Елийн дайг авч нэгэн дай тамбага хийж барив. Ел яаран босож хариу тамбага хийж инээн өгүүллрүүн

Төдий наадмыг хурааж бүгдээр хамт будаа идэх дүр Пү Юй урьд идэж бараад гадна яарч Жян пин дүр суусан дагалдуур олон гунянууд мөн идэж бараад гарч ирж хэрсэгийн доор сууж цай уух ба багана түшин жогсоод тамбага сорох ану мөн буй.

Жин Фүрэн тин олон гунянууд луга орж ирэв. Лу тай тай найр талбин суулгасан хойно Гү Шы тамбага хийлгэж инээн өгүүлрүүн:

Бие дор сиймгэр хувцас өмсөж, гартаа урт дай барин зовох янзаар сууж

Дээрх жишээнүүдэд “нэгэн дай тамбага”, “тамбага сорох ану”, “тамбага хийлгэж”, “урт дай барин” зэрэг тамхитай холбоотой үг хэллэг гарч байгаа бөгөөд “тамхины уут”, “урт тамхины уут” зэргээс үзвэл гаансаар нэрдэг амны тамхийг дүрсэлсэн байна. Мөн гурваас бусад жишээнд ирсэн гийчнийхээ тамхины уутыг дүүргэх юм уу, харилцан тамхилж байгаагаас харахад тухайн үеийн өвөр монголчуудын тамхиар дайлдаг харилцааны хэв дадлыг тусгажээ. Монголчуудын энэхүү уламжлал нь найрсаг харилцааны хэв дадал болж хэвшин үлдсэний нэг баталгаа нь энэхүү хоймсон романд туссан тамхиар дайлах харилцааны ёс юм.

Хадаг бол монгол, төвөд үндэстний оюун сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх чухал эд юм. Хадаг нь анх Энэтхэгээс үүсжээ, XIII зуунд Хятад, Төвөдөөр дамжин Монголд нэвтэрсэн гэж үздэг. Монголын нууц товчоонд хадгийг “хэв” гэж нэрлэсэн байна. Хожим монголчууд “хадаг” гэдэг нэрийг авч хэрэглэх болжээ.

Монголчуудын хувьд хадгийг тэнгэрээс гаралтай, энэ ертөнцөд байдаггүй эд хэмээн үүрийн цагаан гэгээ татах үеийн тэнгэрийн хаяаны өнгөтэй адилтган дүрсэлдэг. Тэнгэрийн эд учраас хөнгөн, зөөлөн, уян бас бат бөх чанарыг бэлгэдэн ертөнцөд түүнээс илүү эд байхгүй гэж үзнэ. Хадаг нь бурхан шүтээн, багш дээдсийн хөрөг, тэргүүтэнд тахих, тахилын шүтээнд мөргөх үед амгалан жаргалан, даатгах, мэнд амар мэдэх утгыг илтгэдэг. Тэр утгын дотоод сэтгэл нь хиргүй цагаан, торго мэт ариун байхын бэлгэдлийг илэрхийлж, харамж өргөх гэсэн утгыг агуулдаг.

Монгол туургатны хуримын ёсонд хадгийг зайлшгүй хэрэглэдэг нь “хадаг тавих”, “хадаг тариа тавих”, “архи хадаг хүргэх”, “найман тахил төгссөн, насан аюуш бүрдсэн, тэгш сайхан энтэй, тэнгэрийн хувцад болсон, алтан торгон хадаг” гэх мэт бэр гуйхтай холбоотой ерөөл магтаалаас гадна “хараал нь хар толгойдоо, хадаг нь бурхандаа”, “хатан заслагаар, хадаг эвлэгээр”

Цаглашгүй урт наст ариун хадаг

Тэгш эрхий тэнгэрээс цэцэглэсэн

Дэлгэрэнгүй урт наст ариун цагаан хадаг

Идээний дээж элгэн цагаан тараг

Эдийн дээж ариун цагаан хадаг (Арьяасүрэн нар, 1992: 492-493)

зэрэг ерөөл магтаал, үг хэллэгээс тодорхой байна. “Монгол ёс заншлын их тайлбар толь”-д “Хадгийг барихдаа өгөх хүн рүүгээ хадгийнхаа амыг хандуулан хүндийн эрэмбээр мэхийх юм уу, сөгдөж барина. Цаад хүн нь хариу мэхэхийн хадгийг хоёр гардан аваад эвхэж хямгадах ёстой.” гэж монголчуудын хадаг барих үйлдлийг тайлбарлажээ.

Өвөр монголын эрдэмтэн В.Сарангэрэл монгол үндэстний хуримын ёсон дахь хадаг тавих уламжлалыг зэрэгцүүлэн авч үзсэн байна. Тэр бээр “хадаг тавих ёсыг цаг үе, орон зай, зорилго зориулалтаасаа шалтгаалан өөр өөр байдаг бөгөөд ураг хуримын ёс заншлын хувьд үе шат бүхэнд хадаг өргөнө. Ингэхдээ тус тусын илтгэх санаа нь ч адилгүй байна” гэж тайлбарласан байдаг.

“Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд хадагтай холбоотой дараах өгүүлэмж бий. Үүнд:

Тэндээс Пү Юй өглөө эрт босож угаан самнасан хойно, ёсны дээл малгайгаа өмсөж урьд Сэ тэнгийн өмнө ирвэл, Гао Жин, Юн Жу, Яо Цин, Бу Жян тан хэдүйн тэнд хүж зул бэлтгэн хүлээсэн тул Пү Юй хадаг өргөн хүж шатаан мөргөн барсан хойно.

Хойш орж Лю Цинээс нэгэн сайн хэв авч Бэй Фү рэнхд хичээнгүйлэн өргөн буй дор Цуй Панийг гуйх учрыг илэрхийлэн мэдэгдэв. Бэй Фү рэнхд хэвийг хүлээн авч инээн өгүүлрүүн.

Дээрх өгүүлэмжид “Пү Юй хадаг өргөн хүж шатаан” гэж гарч байгаа нь хүргэн болсон Пү Юй анх хадмын гэрт байхдаа бурхан шүтээнд нь хүж асаан, хадаг өргөж байгааг дүрсэлжээ. Харин хоёр дахь өгүүлэмжид бэр гуйхдаа хэв өргөн барьсныг Бэй Фүрэнх зөвшөөрсний тэмдэг болгон хүлээн авч байгаагаар дүрсэлжээ.

Эндээс тухайн үеийн Өвөр монголчууд хадгийг хэв гэж нэрлэдэг байсныг харж болохын зэрэгцээ бурхан шүтээнд өргөн барих, мөн бэр гуйх зөвшөөрөл авахад өргөдөг болохыг мэдэж болохоор байна. “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон романд монгол түмний ариун цагаан сэтгэл, хүндэтгэл бишрэлийн илэрхийлэл болсон хадаг барих ёс уламжлал энэ мэт тусгалаа олжээ.

Дүгнэлт

Инжаннашийн “Нэгэн давхар асар”, “Улаанаа ухилах танхим” хоймсон роман нь хятадын уран зохиолын туурвил зүйн уламжлалт аргад түшиглэн, монголын уран зохиолын хүүрнэл болон утга уянгын зохиолын уламжлалыг баяжуулжээ. Үүний нэг илрэл бол тус хоймсон романд оньсого, зүйр цэцэн үг зэрэг монгол ардын аман зохиолын төрөл зүйл; есийн тооны бэлгэдэл, уламжлалт зан заншлын жишээ болсон цаг тооны бэлгэдэл, хадаг барих ёс зэрэг монголын уран зохиолын уран сайхны онцлогийг илэрхийлсэн байна.

Ном зүй

- Арьяасүрэн Р., Нямбуу Х. 1992. *Монгол ёс заншлын их тайлбар толь*. Улаанбаатар. “Сүүлэнхүү” Хүүхдийн Хэвлэлийн газар.
- Байгалсайхан С. 2015. *Уран дүрийн онолын лекцүүд*. Улаанбаатар. Сэлэнгэ пресс.
- Байгалсайхан С. 2015. *Монгол-Хятадын уран зохиолын харилцаа холбооны нэгэн асуудал, “Монголын Хятад судлал I”*. Улаанбаатар.
- Бадамхатан С. 1987. *БНМАУ-ын угсаатны зүй*. Улаанбаатар.
- Насанбалжир Ц. 1964. *Ар Монголоос Манж чин улсад залгуулж байсан алба*. Улаанбаатар.
- Нагааннямбуу Н., Маралмаа Н. 2004. *Монгол ёс заншлын үндэс дээжис*. Улаанбаатар.
- Цао Шюэчинь. 2017. *Улаан асрын зүүд*. Нэгдүгээр боть. Улаанбаатар.
- Сарангэрэл В. 2012. *Монголчуудын заншил соёлын үндэс*. Улаанбаатар. Никель Декель ХХК.
- Хувьсгалт. 2009. *Догсомын Бодоогийн “Үлэмжит өгүүлэл” бол Хятадын “Сувдан цамц” гэдэг зохиолыг орчуулан найруулсан бүтээл мөн*. Магистрын дипломын ажил. УБ-ийн ИС. Улаанбаатар.
- ШУА-ын Хэл Зохиолын хүрээлэн. 1997. *Монголчуудын хуримлах ёс*. Ред. Сампилдэндэв Х. Улаанбаатар. Эрдэм компани.
- Injannasi. 1979. *Nigen dabqur asar I*. Öbür mongyul-un arad-un keblel-un qoriy-a. [Инжиннаши. 1979. *Нэгэн давхар асар I*. Өвөр монголын Ардын Хэвлэлийн хороо.]
- Injannasi. 2018. *Ulaan-a ukilaqu tingkim*. Liyoning. [Инжиннаши. *Улаанаа ухилах танхим*. Ляо Нин., Ляо Нин Үндэстний Хэвлэлийн хороо.]
- 朝格吐. 2017. “蒙古族文学大师尹湛纳希和胡仁乌力格尔·《大西凉》”, 中央民族大学学报, 北京,. [Цогт Б. 2017. *Монгол үндэстний бичгийн их хүмүүн Инжаннаши болон хуурын үлгэр “Их баруун Лян”*, “Төвийн үндэсний их сургуулийн эрдэм шинжилгээний өгүүлэл”. Бээжин.]
- 中央民族大学. 2004. *中国民族志*. 北京,. [Төвийн Үндэсний Их Сургууль. 2004. “*Хятадын угсаатан зүй*”. Бээжин.]